



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/18/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.05.05 № 294
танай _____ ны № _____ т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГА Н.ПҮРЭВСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,483.2 сая төгрөгөөр буюу 41.7 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны А/96 дугаар тушаалаар "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-г баталсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай

6326050427

хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,220,574.5	4,649,134.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	338,833.2	361,574.8
	Нийт хөрөнгийн дүн	3,559,407.7	5,010,709.7
	Нийт өр төлбөрийн дүн	3,607.0	8,128.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,555,800.7	5,002,581.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,559,407.7	5,010,709.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,522,107.6	2,439,216.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,407,196.3	999,774.9
	Үйл ажиллагааны үр дүн	3,114,911.3	1,439,441.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(560.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,114,911.3	1,438,881.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	440,889.3	3,563,700.5
	Тайлант оны үр дүн	3,114,911.3	1,438,881.2
	Эцсийн үлдэгдэл	3,555,800.6	5,002,581.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,264,578.7	969,969.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,264,578.7	969,969.3
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	991,967.4	828,918.2
	Урсгал зардал	991,967.4	828,918.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	991,967.4	828,918.2
	Улсын төсвөөс санхүүжих	991,967.4	828,918.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь мал үржлийн алба, үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний алба, захиргаа аж ахуйн гэсэн 3 албатайгаар төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх бодлого, шийдвэр, хөтөлбөрүүдийг аймагтаа хэрэгжүүлэн ажилласан байна.

“Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн

өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн, үйл ажиллагааны 10 стратеги зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааны хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 6 зорилт, 96 арга хэмжээг хэрэгжүүлэн, аймгийн Засаг даргаар 2025 оны А/815 дугаар захирамжаар 86.9 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт Засгийн газрын 2023 оны 41, 112 дугаар тогтоолоор,

Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар,

Импортын барааны гаалийн албан татвараас хөнгөлөх хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийн жагсаалтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2023 оны А/107 дугаар тушаалаар,

Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журамд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2023 оны А/243, 521 дүгээр тушаалаар тус тус нэмэлт өөрчлөлт орсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны А/96 дугаар тушаалаар "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-г баталсан байна.

Тав. Аудитын гол асуудал

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,483.2 сая төгрөгөөр буюу 41.7 хувиар өссөн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд эхний хагас жилийн санхүүгийн тайлан, батлагдсан төсөв, гүйцэтгэл- хөтөлбөр зориулалт, эдийн засгийн ангилал, байгууллагын батлагдсан төсөвт орсон өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 5 төрийн мэдээллийг хугацаа хоцроож, Төсөв, өмч, хөрөнгө зарцуулахтай, өр авлага үүсгэсэн шийдвэрийг 1,2,9-с бусад саруудад оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.

Энэ шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайланд онд аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн Б/62 дугаар захирамжаар байгууллагын дарга, газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Б/31 дүгээр тушаалаар нягтлан бодогч нар томилогдсон байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2025 оны жилийн эцсийн байдлаар тус газрын 41.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 1 албан шаардлагын хэрэгжилт биелэгдээгүй байна.

Иймд дараагийн аудитаар анхаарах асуудалд өмнөх шийдвэрийн биелэлтэд горим сорил хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 32.5 сая төгрөгийн алдаа, зөрчил 1 илэрснээс 31.8 сая төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй 0.4 сая төгрөгийн 1 алдаанд зөвлөмж, 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 0.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9.2 сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Төрийн захиргааны алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид үндэслэлгүйгээр дутуу тооцож 0.3 сая төгрөгийг олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" зөрчсөн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр илүү тооцож олгосон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд олгосон 0.3 сая төгрөгийн зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: 2025 оны санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл, 2024 аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс 0.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх. Аудитлагдсан тайлангийн үлдэгдлийг өөрчлөхгүй байх.

Илрүүлэлт 2: Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг заасан байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө өглөг, авлагыг заавал бүртгэж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөд бүртгэсэн байсан 6 ширхэг компьютерийг бараа материалын тайлангийн тусгай зориулалтын бараа материалын дансанд бүртгэсэн.	2	31.8			2	31.8	2	31.8				
Дүн	2	31.8			2	31.8	2	31.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид үндэслэл, шийдвэргүйгээр нэмэгдүүлэн олгосон.	1	0.3	1	0.3								
Аудитлагдсан тайлангийн үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн.	1	0.4					1	0.4				
Дүн	2	0.7	1	0.3	-	-	1	0.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд эхний хагас жилийн санхүүгийн тайлан, батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр зориулалт, эдийн засгийн ангилал, байгууллагын батлагдсан төсөвт орсон өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 5 төрийн мэдээллийг хугацаа хоцроож, Төсөв, өмч, хөрөнгө зарцуулахтай, өр авлага үүсгэсэн шийдвэрийг 1,2,9-с бусад саруудад оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0